

“ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 29-ний өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Компанийн 2016 оны үйл ажиллагаа, диспетчерийн зохицуулалт,
горим төлөвлөлт, төлөвлөгөөний биелэлтийн дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, компанийн дүрмийн 9.3.8, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын 2.9.6, 2.11.4 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн 2016 оны нэгдсэн системийн цахилгаан, дулааны горимын төлөвлөлт, системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангасан диспетчерийн зохицуулалтын үйл ажиллагааг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2. Цаашид эрчим хүчний нэгдсэн сүлжээний найдвартай, тогтвортой ажиллагаа, цахилгаан, дулааны үйлдвэрлэл-хэрэглээний тэнцвэржилтийг хангах, эрчим хүчний шуурхай зохицуулалтыг гүйцэтгэх, салбарын хэмжээний шуурхай мэдээ, мэдээллээр цаг алдалгүй хангаж ажиллахыг гүйцэтгэх захирал /Д.Балдорж/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ДИСПЕТЧЕРИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ҮНДЭСНИЙ ТӨВ ХХК Д.ЧИМЭДДОРЖ

ТТА А 0673
2699877